**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 05 өдөр Дугаар А/351 Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Математикийн улс, бүсийн олимпиадад 3 мөнгө, 5 хүрэл медаль, аймгийн 2 мөнгө, 3 хүрэл медаль, 2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтаар 720 оноогоор тэргүүлсэн Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн сурагч Цолмон овогтой Цэрэнгийн оюутны төлбөрт 1’500’000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 1’500’000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4822111168